


Хичээл эхлэхийн
өмнө сурах бичиг,
дэвтэр, үзгээ бэлдэн
дэлгэцдээ ойртон
суугаарай.



Эхээс мэдрэмж
сэтгэгдлийг ялган,
зохиогчийн сэтгэлийн
өнгө аясыг тайлбарлах



Германы [Майны Франкфурт](#) хотод 1929 онд төрсөн. Түүний бичсэн өдрийн тэмдэглэл нь [Дэлхийн II дайны](#) үеийн байдал, өөрийн амьдралдаа мэдэрсэн баяр хөөр, айдас гунигаа бичин үлдээж чадсанаараа дэлхийн алдартай нийтлэлийн нэгд зүй ёсоор багтдаг.

Түүний амьдралын ихэнх өдрүүд [Нидерланд](#) улсын [Амстердам](#) хотод өнгөрсөн байна. Анна 1942 оны зунаас эхлэн өдрийн тэмдэглэлээ хөтөлж эхэлжээ.

1945 онд буюу [15 насандаа](#) "Берген-Белзен" дэх еврейчүүдийг олноор хорих лагерьт нас барсан юм.

Түүнийг нас барсны дараа хэвлэгдсэн "[Аннагийн өдрийн тэмдэглэл](#)" ном нь дэлхийн сонорт хүрч алдаршсан билээ.



Анна Франк
1942 он

1943 оны долоодугаар сарын 26 Даваа гараг
Хайрт Китти минь!

Өчигдөр ганц ч агшин тайван байсангүй. Бүгд л сэтгэл түгшиж өнжив. “Ингэхэд ер нь айж сандрахгүй өдөр гэж та нарт байна уу?” гэж чи гайхаж байна уу?

Дөнгөж цайгаа уух гээд сууцгаатал түгшүүрийн урьдчилсан дохио хангинаад явчихлаа. Энэ нь дайсны онгоц тэнгисийн эрэгт ойртож явааг дохиолох тул бид нэг их сандарсангүй. Миний толгой өвдөөд байхаар нь өглөөний цайны дараа хэсэг дуг хийгээд дараа нь доош буув.

Цаг хоёр хагас болж байлаа. Биднийг дээш гараад таван минут болов уу үгүй юу, хүмүүс гадаа сандран бужигналдаж гарлаа. Бид ч бөмбөгдөлтөөс зугтан хонгил руу орж хорогдлоо. Байшин доргиж, дэргэд бөмбөг тэсрэх сонсогдов. Би ч “Зугтах хэрэг магад” гээд ойр зуур юм чихсэн цүнхэрхүү юмаа тэврэн суув. Гэвч бид зугтаад ч хаачих юм билээ. Гадаа гудамжинд гарах нь бөмбөгдөлтөөс ч долоон дор аюултай юм чинь. Бөмбөгдөлт өнгөрөөгөөд хагас цаг болсны дараа бид дээш гарахад “ИЕ” хэмээгч Амстердамын боомт зогсоолоос бөөн утаа олгойдон, уугьж харагдсанаа төдөлгүй түймрийн утааны үнэрээр солигдон, хот нэлдээ гүн хар утаанд умбав. Тийм их түймэр гэдэг сонирхоод баймаар юм биш ажээ.

Тодруулсан өгүүлбэрт сэтгэлийн ямар өнгө аяс илэрч байна вэ?
Тайлбарлан бичээрэй.

Дайны үеийн айдас хүйдэс, энэлэл шаналал, цочрол цөхрөл.

- Бүгд л хором бүр сэтгэл түгшүүртэй таагүй байгаа
- 5 минут бололгүй л бөмбөгдөлтөд өртөж буй айдас
- Хаачхаа ч мэдэхгүй горьдлого, мухардалд орж цөхрөнгөө барсан
- Бөмбөгдөлтөөс үүдсэн айдас, туйлдсан.

Орой хоолны үеэр бас л агаараас түгшүүр. Хоол үнэхээр сайхан байсан ч түгшүүрийн дохионы ёнгинооноос болоод юу ч хоолой давдаггүй. Дөчин таван минут хэртэй чимээгүй байснаа дахиад л агаараас эсэргүүцэх буунууд нижигнэн, сав суулга угааж дуусав уу үгүй юу дахиад л түгшүүрийн дохио хангинаж, дээгүүр онгоцнууд дүнгэнэж гарав. Би тэгэхэд “Бурхан минь, битгий л галзуурчхаж үзээрэй” гэж залбирч суулаа. Мэдээж залбирал өчүүхэн ч тус болсонгүй. Бөмбөг бороо шиг асган, англичүүдийн түрүүнд нь мэдээлж байснаар Амстердамын “Шипол” нисэх онгоцны буудал руу мөндөр мэт цутгав. Нисгэгчид онгоцтойгоо нэг шумбан, нэг хөөрөн хэсэг шүршин буудалцах нь тэр чигээрээ тэнгэр буцлах мэт.

Тодруулсан хэлцэд ямар сэтгэлийн өнгө аяс илэрч байна вэ? Тайлбарлан бичээрэй.

ДАЙН гэдэг ямар их аймшигтай байдаг, түүнийг даван туулах гэж буй 13-хан настай жаалхан охины сэтгэлийн шаналал, айдас хүйдэс нэвт мэдрэгдэж байна.

- Маш их цочрол
- Туйлдал, цөхрөл, айдас
- Айсан түгшсэн, мэгдсэн сандарсан

Эгшин бүрд л “Тэдний нэг нь дээрээс уначих вий” гэж айхдаа зүрх дэлссэнийг хэлээд яахав. Орой 9 цаг хажуулахад бараг хоёр хөл дээрээ зогсож чадахааргүй ядарчихсан байснаа чамд хэлье.

Шөнө дөлөөр бас л сэрж, 12 цагийн үед мөн л “Онгоц дээ” гэцгээв. Эхний бөмбөгдөлтөөр л орноосоо огло үсэрсэн дээ. Хоёр цаг хэртэй онгоц дүнгэнэв. Тэгтэл буудалцаан ч зогсож, өрөө рүүгээ буцах болов. Хоёр цаг хэртэй унтах санаатай хажуулдав.

Өглөөний 7 цаг болж байв. Бас л чимээ гарахаар нь айж сандран аав руу очвол Даан гуай ирчихсэн сууна. Даан гуай өчнөөн сарын турш сонсоогүй чихэнд чимэгтэй мэдээ хэлэх гэж явсан юмсанжээ. Муссолини огцорч, Италийн ван дахин засгийн эрхийг авч гэнэ. Бид хөөрөн баярлацгаав. Өчигдрөөс эхлэн үнхэлцгээ хагартал айж сандарсны дараа ингэж сайхан мэдээ олж авах гэж муу юм цаашилж, сайн юм наашлах зөн шүү.

Дараа шөнө бас л түгшүүрийн дохио бас л онгоцны дүнгэнээн. Түгшүүрийн дохионоос сэтгэл хямран унтаж ч, ажиллаж ч чадахаа болилоо. Харин “Муу юм төгсөнө” гэсэн итгэл л биднийг зоригжуулна гэж горьдож байна даа.

Анна

Бүтээврүүд сэтгэлийн ямар өнгө аясыг тодруулж байна вэ?

Тайлбарлан бичээрэй.

Тухайн үйл явдал болон дүрслэлийн санааг илүү их онцолсон, баталсан, лавшруулсан, нотолсон.

Сүүлийн 2цогцолборт сайн сайхан болно гэсэн горьдлого, хүсэл мөрөөдөл түлхүү мэдрэгдэж байна.

Өдрийн тэмдэглэлийг уншаад чамд ямар мэдрэмж төрөв?

- Дайныг үзэн ядсан.
- Айж жихүүцсэн.
- Түгшиж сандарсан.
- Цөхөрч туйлдсан.
- Өрөвдөж хайрласан.

Гэрийн даалгавар

“Анна Франкийн
өдрийн тэмдэглэл”-
ийг уншаарай.

Өдөр бүр тэмдэглэл
хөтөлж хэвшээрэй.

